

УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ ГОВЬСҮМБЭР
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ



СУРЛАГЫН ХОЦРОГДЛЫГ АЖЛЫН ХУУДСААР НӨХӨХ, ҮНЭЛЭХ, ХЯНАХ БОЛОМЖ

Монгол хэлний багш: А.Шинэбаяр

Амьдрах ухааны багш А.Оюунгэрэл

Чойр хот
2022 он

БҮТЭЦ

ОРШИЛ

- ✓ Товч агуулга
- ✓ Түлхүүр үг
- ✓ Үндэслэл
- ✓ Зорилго
- ✓ Зорилт
- ✓ Онол
- ✓ Судалгааны арга
- ✓ Судалгааны хэсэг
- ✓ Практик ач холбогдол
- ✓ Дүгнэлт
- ✓ Дэвшүүлж буй санаа
- ✓ Ном зүй



ОНОЛЫН ХЭСЭГ

- 1.1. Багш сургалтыг дэмжих үйл ажиллагаа
- 1.2. Мотивацийн тухай менежментийн ойлголт
- 1.3. Хьютагог
- 1.4. Дадал хэвшил

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

- 2.1. Судалгааны арга зүй, аргачлал
- 2.2. Багш нарын ажлын туршлага
- 2.3. Бусад багш нараас туршлага солилцох
- 2.4. Судалгааны хамрах хүрээ, үр дүн

ДҮГНЭЛТ

НОМ ЗҮЙ

Оршил

Түлхүүр үг:

1. Хоцордол
2. Ажлын хуудас
3. Дадал хэвшил
4. Үнэлгээ

Үндэслэл

2020-2021 оны хичээлийн жилд нийт сургалтын хөтөлбөрийн хүрээнд хүрэх үйл ажиллагааны 45 хувийг зайнаас буюу төлө, цахим хэлбэрээр оржээ. Харин төлө болон цахим сургалтын хүрээнд сургалтын хүртээмжгүй байдлаас үүдэн тухайн суралцаж байгаа түвшний мэдлэгээ хүүхэд авч чадахгүй байх, өдөр бүрийн төлө сургалтад заах арга барилын шинэ арга туршлагуудыг нэвтрүүлэхгүй байснаас үүдэн улсын хэмжээнд нийт ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийн явцын оролцоо өмнөх оноос 20 хувь буурсан статистик байна. Ингэснээр хичээлийн хоцордол үүсэх, хүүхэд сурах сонирхолгүй болж байгаа тохиолдлууд нэмэгдэж байгаа юм.

Хамгийн сүүлийн үеийн буюу 2021 оны 12 дугаар сарын статистикаар улсын хэмжээнд хөл хороо тогтоож, сургууль цацарлалтын үйл ажиллагааг зогсоосонтой холбоотойгоор 93 их дээд сургууль, коллежийн 148.4 мянган оюутан зайны сургалтад хамрагдсан гэсэн тоон судалгаа гарчээ. Тэвэл суралцаж хоцордсон хичээлээ хэрхэн дахин судлах вэ? цаашид сургалтын хөтөлбөрт ямар өөрчлөлт оруулах, нийт суралцаж, багш нараас хичээл сургалтын хүртээмжтэй байдлыг хангах, сургалтын хоцордлыг арилгах үр дүнтэй сургалтыг зохион байгуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ гарч байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас байгуулагдсан ажлын хэсэг тооцоо судалгаанд үндэслэн суралцагчдын хоцордол нөхөх, арилгах /2021-2023 он/ гурван жилийн цогц төлөвлөгөө боловсруулаад байна. Цогц төлөвлөгөөнд 3 зорилтыг тусгаад байгаа юм.

“Залгамж холбоот тогтоох”

“Сургалтын хоцордлыг нөхөн засах”

“Сургалтын хоцордлыг арилгах, тогтворжуулах”

Харин бид “Сурлагын хоцрогдлыг нөхөн засах, Сурлагын хоцрогдлыг арилгах, тогтворжуулах” зорилтын хүрээнд өөрийн сургуулийн хөтөлбөрт суурилсан, багш нарын ажлын хуудас боловсруулах арга зүйн онцлог, туршлагыг судалж, түгээн дэлгэрүүлэх, хоцрогдлыг арилгах, үнэлэх шаардлага тулгараад байна.

Зорилго: Ажлын хуудсаар сурлагын хоцрогдлыг нөхөх, үнэлэх, хянах боломжийг туршиж ажлын хуудсын дэвтэр боловсруулах санал гаргах.

Зорилт:

1. Өөрийн боловсруулсан ажлын хуудсыг туршиж сайжруулах
2. Багш нарын санал асуулга болон ажлын хуудас боловсруулалтад харьцуулалт дүгнэлт гаргах
3. Сургуулийн онцлогийг илэрхийлсэн загвар бүхий ажлын хуудсын дэвтэр боловсруулах санал дэвшүүлэх

Судалгааны арга: Энэхүү судалгааг асуулга, индукц, дедукц гаргалгааны арга болон нэгтгэн дүгнэх аргыг хэрэглэв.

ОНОЛЫН ХЭСЭГ

1.1. Батш сургалтыг дэмжих үйл ажиллагаа

Батш бол боловсролын бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэгч эзэн нь мөн учир батшийн мэргэжлийн чадвар, хандлага улс орны хөгжлийн үндэс байдаг. Боловсрол гэдэг нь сургалтын явцад олж авсан мэдлэг, үр чадвар, сэтгэлгээний тогтолцоо юм. Сургалт гэдэг нь боловсролын тодорхой зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн батш сургалч 2-ын хамтын бүтээлч үйл ажиллагаанаас бүрдэх, хоёуланг нь чанарын өөрчлөлт гаргах зорилготой түвний зорилго, агуулга нь суралцагчийн хэрэгцээ нийгмийн шаардлагаар тодорхойлогдож, тэдгээрийг хэрэгжүүлэх чиг хандлага, арга технологийг батш тодорхойлж чиглүүлэн жолоодох үйл явц юм.

Нийгмийн байгуулал хөгжиж, хүмүүсийн хэрэгцээ өргөжин түршлэл хуримтлагдахын хирээр сургалт өөрчлөгдөн түвний зорилго, агуулга, аргазүй зэрэг нь улам боловсронгуй болж ирсэн түүхтэй. Нийгмийн хөгжилтэй уялдаж тухайн хүний нийгэмд амьдрах хувь хүнд зайлшгүй шаардлагад наад захын мэдлэг, чадвар, үр ухаан нь байнга шинэчлэгдэн өсч байдаг.

Батшийн сургах үйл ажиллагаа. Батшийн сурган хүмүүжүүлэх үйл арга ажиллагаа нь суралцагч бэлэн мэдээлэл дамжуулалч, хянагч, шалгалч байх бус суралцагчдын танин мэдэх үйлийг сэдэжүүлэх, идэвхжүүлэх, хамтран ажиллах, туслан зөвлөх, хэрэгцээ онцлогийг судалдаг судлаач, суралцагчдын сурч танин мэдэх төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулалч менежер байх болсон. Сургалтад батшийн гол үүрэг нь суралцагчид сургах үйл ажиллагааг чиглүүлж жолоодоход оршино. Батш нь суралцагчид сургах ёстой зүйлийг дамжуулан заах бус, сургах үйлдээ хандах хандлагыг төлөвшүүлж зорилго зорилтоо ухамсартай тодорхойлж хэрэгжүүлэх арга зам, хэрэглэх зүйлсээ оновчтой сонгоход нь туслан алдаа гархаас сэргийлж, гаргасан алдаа доромдлыг нь цаг алдалгүй засах зорилгыг тавьж ажиллах нь чухал. Батшийн сургах үйл ажиллагааны зорилго нь суралцагчдад их хэмжээний мэдлэг чадвар эзэмшүүлэхэд бус, тэднийг цаашид бие даан суралцаж өөрийгөө хөгжүүлж нийгмийн хэрэгцээ шаардлагад зохицон ажиллаж амьдрах чадвартай болоход оршино. Батшийн сургах үйл ажиллагаанд сургах үйлийг хянаж, үнэлж дүгнэх элемент багтах бөгөөд юу мэдэж чадаж байгааг үнэлэхээсээ илүү сургах үйлийн арга барил эзэмшиж буй байдал, хөгжил төлөвшилийнх нь хандлагыг оновчтой хөтлөх чиг баримжааг олохыг хичээх нь чухал.

Хэрэглэгчид хүүхдүүн-хүн өр нь юунд суралцагч вэ? Хүн үйлэнд суралцагч. Тэрхүү үйлийг орчин бий болгож байдаг. Таатай орчин:

1. Материаллаг орчин /анги, сургалтын хэрэгсэлдэхүүн/

2. Сэтгэлзүйн орчин /сургах, сургах сонирхол, тэмүүлэл, чармайлт, нийгмийн сэтгэлзүй,

үнэлэмж/

3. Үйлийн орчин: /Балш-шавь- эцэг эхийн хамтын үйл ажиллагаа/
 3. Сургалтын үр дүн, үнэлгээ үйл ажиллагаа явагдаж байгаа учраас түүний явц, хүрэх үр дүн хоёрын хамаарлыг алхам тутамд хянан шинжлэх шаардлагатай. Амжилт болон доролдлын шалтгаан юу байв? гэдгийг эрт оношилж сайжруулахад үнэлгээ хяналт шинжилгээ чухал үүрэгтэй. Аливаа сургалтын үр дүн нь суралцахад гарч байгаа төлөвийн өөрчлөлтөөр хэмжигдэнэ. /юун ухаан, үр чадвар, ёс суртахуун/ Суралчдын гүйцэтгэсэн ажлын тоог бүртгэж үнэлдэг хандлагаас гүйцэтгэх чадварт гарч буй өөрчлөлтөөр үнэлдэг, үнэлүүлэхийн тулд гүйцэтгэдэг байр сууринаас алдаа оноог илрүүлэхийн тулд гүйцэтгэдэг байр суурь руу шилжих шаардлагатай болж байна.

1.2. Мотивацийн тухай мөнөжментийн ойлголт.

Мотиваци нь харилцаа, сэдэл тэмүүлэл, сонирхол, хүчин чармайлт зэргийг багтаасан өргөн ойлголт юм. Мотиваци хүний амьдралын өсөлт, хөгжил, үйл ажиллагааны бүх шатанд нөлөөлдөг. Ямар нэг зүйлийг сайн хийх, амжилтанд хүрэх хүсэл зориг нь ихэнхдээ хүмүүсийг удирдан залгах хүч, хөгжил төлөвшил, идэвх, сэдэл тэмүүлэл зэрэг дотоод хүчин зүйлд, холбогдох бөөгд амьдралдаа идэвхтэй байх, санаачилга гаргах, бүтээлчээр ажиллах үндэс болдог аж. Хөдөлгөөн (mots) гэсэн утгатай латин үгнээс гаралтай мотиваци хэмээх ухагдахууныг эрдэмтэд, судлаачид олон янз байр сууринаас үзэж тодорхойлдог боловч дор дурдсан гурван гол чиглэлд санал нэгдэх хандлагатай байдаг. Үүнд нэг. мотиваци нь үйл ажиллагааг өдөөгч, хоёр. хүний зан үйлийг удирдаж, түүнийг чиг зүг, зохион байгуулалт, идэвх, тогтворжилтыг тодорхойлогч физиологийн болоод психологийн хувьд динамик үйл явц, гурав. материаллаг хэрэгцээгээ ажил үйлсээр дамжуулан, хангах хүний чадвар нэмсэн өргөн хүрээ бүхий ойлголт ажээ. Мөн мотивацийг гадаад мотиваци (экстринсив), дотоод мотиваци (интринсив) гэсэн хоёр төрөлд ангилсан байдаг. Тодорхой үйл ажиллагааны агуулгатай холбоотой, субъектэй харьцуулахад гадаад нөхцөл байдлаар үүсгэгдсэн мотивацийг гадаад, харин гадаад нөхцөл байдлаар холбоотой, үйл ажиллагааны агуулгатай холбоотой мотивацийг дотоод мотиваци гэжээ.

Түүнчлэн мотивацийг:

- Хувь хүний мотиваци буюу гомеостазийг барьж байхад чиглэсэн:
- Бүлгийн мотиваци
- Танин мэдэхүйн мотиваци

✓ Судлан мэдэх зан үйл

✓ Тоглоомын үйл ажиллагаа гэх зэргээр ангилсан байдал

Энэ мэтээр мотивацийн тухай олон нэвч олон баримтлал, тодорхойлолт бий боловч хувийнхаа болон бүлгийнхнээ зорилгыг хэрэгжүүлэхэд өөрийгөө түүнчлэн бусдыг өдөөн идэвхжүүлэх гэсэн санаа илүү давамгайлах магадлалтай. Хувь хүний ажил сургуульдаа гаргасан хүчин чармайлтын түвшин, чиглэл, шаргуу чанарыг агуулсан дотоод өргүүлбэр

(санаа, сэдэл) хэмээн мотивацийг үзэж болно. Багш хүн хөгжлийнхөө үе шатад өсөж хөгжихдөө гол чадвар болох агуулга-арга зүйн мэдлэгээ сайжруулахад тухайн багш өөрийгөө болон бусдыг идэвхжүүлэх нь сурагчдын хөгжлийг дэмжих юм.

1.3. Хьюатар

Хьюатар нь бие дааж сурагчдын талаарх орчин үеийн үзэл баримтлал бөгөөд сургалтын цөм нь өөрсдийн сурах үйл явцыг бие дааж удирдан залах ухамсартай залуучууд, насанд хүрэгчид байдаг. Хьюатар нь мэдээлэл технологийн үсрэнгүй хөгжил, ажлын байрны чанарын өөрчлөлт, хөдөлмөрийн зах зээлийн хүмийдал, эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгэм, хөдөлмөр эрхлэлт болон боловсролын хэрэгцээ ихэссэнтэй уялдан дэлхийн улс орнуудад гарч буй өөрчлөлтийн нийгмийн хариу үйлдэл болж үүссэн. Хьюатар-ийн үндэс нь орчин үеийн насан туршийн боловсролын үзэл баримтлалтай нийцэж байна (Игнатович Е.В, 2013). С. Хасе болон К. Кеньон хэлэхдээ «heutagogу буюу орчин үеийн бие дааж сурагчдын ухаан нь хүмүүнлэгийн болон 1950-иад оны сурагчдын талаарх онол, арга зүйд тулгуурласан. Хьюатар нь 21-р зууны сурагчдын боловсролын хэрэгцээг хангах, ялангуяа хувь хүний чадварыг хөгжүүлэхэд зориулагдсан» гэж үзжээ. Хьюатарийн талаарх онолыг бид боловсролын салбарт, ялангуяа насан туршийн боловсролын хэрэгцээ өндөрөөр тавигдаж буй өнөө үед сурагчдын бие дааж сурагч арга барилыг шат шатандаа хөгжүүлэх, нээлттэй болон цахим сургалтын практикт хэрэглэн турших нь цаашид бүрэн дүнд, мэргэжлийн боловсролын салбарын хөгжилд ихээхэн ач холбогдолтой гэж үзсэн. Энэхүү онол нь багш ажиглах хугацаандаа ажлын байран дээрээ хөгжиж буйх үе шатад олон чадваруудыг эзэмшиж байдал боловч багш бүр харицан адилгүй хөгжсөн байдаг. Иймд хөгжсөн багшийг бий болгохын тулд бие даан сурагчид чадварыг хөгжүүлэх нь чухал байна.

1.4. Дадал хэвшил

Аливаа дадал нь үчилт (cue), үйлдэл (routine), урамшил (reward) гэсэн гурван хэсгээс тогтдог. Үчилт гэдэг нь тухайн зүйлийг өдөөж буй, эхлүүлж буй хүчин зүйл буюу шалтгаан юм. Харин routine нь тухайн дадлыг биежүүлж буй тэр үйлдэл. Урамшил нь энэ үйлдлийг дахин давтах ёстой эсэхийг тархинд сануулах хүчин зүйл юм. Аливаа зөв дадлыг бий болгоход энэ гурван хэсгийг сайн ойлгох нь чухал. Сурагчдад дадал хэвшил төлөвшүүлэхэд нэг зүйлийг олон давтамжаар дахин дахин хийх нь чухал байна.


Түршилт судалгааны хэсэг

2.1 Судалгааны арга зүй, аргачлал

Судалгааны арга: Дээр авч үзсэнчлэн онолын ном зохиол судлах болон индуктив, дедуктив гаргалгааны аргыг хэрэглэв. Энэ судалгаа нь индуктив, дедуктив аргад тулгуурласан болно.


Практик ач холбогдол

Зорилт 1. Өөрийн боловсруулсан ажлын хуудсыг түршиж сайжруулах



Ээлжит хичээл бүрээр ажлын хуудсыг боловсруулан сургалтад ашигладаг байсан.

Давуу тал	Сул тал	Сайжруулах санал
- Хүүхэд бүрт хүртээмжтэй ажлын хуудсыг бэлтгэн ашигладаг. - Ихэвчлэн тарааж өгөх - Материалаар өмнөх хичээлийн агуулгыг бататгаж байсан - Өдөр бүр суралцагч нэг бүрийг үнэлэх боломжтой. - Олон төрлийн даалгавар тус тусад нь боловсруулан хэрэглэдэг	- Ажлын хуудсыг олноор хэвлэхэд цаг хугацаа их ордог - Цаас, хор их ордог - Ажлын хуудсыг уламжлалт аргаар өгдөг - Зарим тохиолдолд дахин ашиглах боломжгүй болдог - Суралцагч бүрийг үнэлэхэд ачаалал их, цаг их ордог - Олон төрлийн даалгавар холигдож эмх цэгцгүй байдал бий болдог	- Ажлын хуудсыг нэгтгэн ашиглах - Ажлын хуудсыг нэгж хичээлээр - Олон төрлөөр - сонирхолтой, өнгө үзэмжтэй, дахин ашиглах боломжтой - бэлтгэх



Давуу тал	Сул тал	Сайжруулах санал
➢ Нэгж хичээлээр ажлын хуудсыг боловсруулсан ➢ Хүүхэд бүрт хүртээмжтэй ажлын хуудсыг дэвтэр болгон ашигласан. ➢ Цаас, хор харьцангуй бага орсон ➢ Олон төрлийн даалгавар нэгтгэж сургалтад ашигласан ➢ Бие дааж хийх боломжтой	➢ Онолын ойлголт байхгүй ➢ Зөвхөн ангид хэрэглэгддэг ➢ Суралцагчийг үнэлэх боломжгүй ➢ Дэвтэрт хуулж бичиж даалгаврыг гүйцэтгэх шаардлага гарсан. ➢ Эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг тодорхойлоогүй.	➢ Ажлын дэвтрийг гүйцэтгэхэд суралцагчдад хялбар болгох ➢ Өөрийгөө үнэлэх боломж олгох ➢ Багш суралцагчийг үнэлэхэд хялбар болгох ➢ Эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг тодорхойлох.

Нэгж хичээлээр ажлын хуудсыг дэвтэр болгон ашигласан.

Нэгж хичээлээр ажлын хуудсыг давтар хэлбэрээр ашигласан. Ажлын хуудсыг сурагчдагчдын түвшинд тохируулан боловсруулдаг болсон.



МОНГОЛЫН ХАМГААГАХ, АЖЛАХ, ХӨДӨӨ АЖ АХуйн яам

Хөгжлийн үйлчилгээний газар

Хөгжлийн үйлчилгээний газар



МОНГОЛЫН ХАМГААГАХ, АЖЛАХ, ХӨДӨӨ АЖ АХуйн яам

Хөгжлийн үйлчилгээний газар

Хөгжлийн үйлчилгээний газар



МОНГОЛЫН ХАМГААГАХ, АЖЛАХ, ХӨДӨӨ АЖ АХуйн яам

Хөгжлийн үйлчилгээний газар

Хөгжлийн үйлчилгээний газар



МОНГОЛЫН ХАМГААГАХ, АЖЛАХ, ХӨДӨӨ АЖ АХуйн яам

Хөгжлийн үйлчилгээний газар

Хөгжлийн үйлчилгээний газар



МОНГОЛЫН ХАМГААГАХ, АЖЛАХ, ХӨДӨӨ АЖ АХуйн яам

Хөгжлийн үйлчилгээний газар

Хөгжлийн үйлчилгээний газар



МОНГОЛЫН ХАМГААГАХ, АЖЛАХ, ХӨДӨӨ АЖ АХуйн яам

Хөгжлийн үйлчилгээний газар

Хөгжлийн үйлчилгээний газар



МОНГОЛЫН ХАМГААГАХ, АЖЛАХ, ХӨДӨӨ АЖ АХуйн яам

Хөгжлийн үйлчилгээний газар

Хөгжлийн үйлчилгээний газар


Давуу тал		Сул тал		Сайжруулах санал	
➤ Нэгж хичээлээр сурагчаахуйн зорилтын хүрээнд ажлын хуудсыг боловсруулсан		➤ Ижил төрлийн даалгавар олон орсон.		➤ Олон даалгаврыг сонирхолтой аргаар шийдэх	
➤ Хүүхэд бүрт хүртээмжтэй ажлын хуудсыг давтар болгон ашигласан.		➤ Өнгө үзэмж, дизайн, анхаарах хичээлд ашиглах боломжгүй		➤ Сургуулийн нэгдсэн нэг загварт оруулах	
➤ Өөрийгөө сорих даалгавар орсон.				➤ Цахим хэлбэрээр хийх	
➤ Бие даан гүйцэтгэх боломжтой болсон.					
➤ Намзлт даалгавар оруулсан					
➤ Сурагчдын хонгордлыг хянах боломжтой болсон					
➤ Багш сурагчдийг үнэлэхэд хялбар болсон					
➤ Эзэмших мэдлэг, чадварыг тодорхойлсон					

Зорилт 2


2.1 Багш нарын санал асуулга болон ажлын хуудас боловсруулалтад харьцуулалт дүгнэлт гаргах

Судалгааны асуулга

1. Та ажлын хуудас боловсруулдаг уу?




2. Та ажлын хуудас /дасгал даалгавар/-ыг хичээл бүр дээр ашигладаг уу?




Ажлын хуудас /дасгал даалгавар/-аар хоцрогдлыг арилгах боломжтой юу


16 хариулт



3. Та сурлагын хоцрогдлыг хэрхэн нөхөж байна вэ?




4. Та хоцрогдлыг нөхсөн эсэхийг хэрхэн үнэлдэг вэ?



5. Ажлын хуудас /дасгал даалгавар/-ыг ямар төрлөөр боловсруулбал илүү үр дүнтэй болох вэ?

- Задгай болон олон төрлийн сонирхолтой аргаар
- Ажлын хуудас дадлага хичээл хийхэд тохиромжтой технологийн карт
- Кейс дээр тулгуурлсан
- Сэдэвтэй уялдуулах дасгал ажиллуулах
- Ажлын хуудас
- Хосолсон арга хэлбэр ашиглавал гэсэн саналууд гарсан.


Багш нарын боловсруулсан ажлын хуудас



Багш нар сурлагын хоцрогдлыг ихэвчлэн гэрийн даалгавар, ажлын хуудсаар нөхөж байгаа бөгөөд хоцрогдол арилсан эсэхийг хичээлийн явцад болон явцын үнэлгээгээр дүгнэдэг байна. Багш нарын боловсруулсан ажлын хуудсанд анализ хийхэд үнэлгээний даалгаврын тавил ойролцоо, үнэлгээний хэсэг ихэвчлэн тодорхойгүй байна. Нүүр хэсэг гарчиг, лого, сургуулийн нэр гэх мэтээр ерөнхийдөө ижил, багш бүр хичээлийнхээ онцлогт тохируулан хийжээ.

Зорилт 3

Сургуулийн онцлогийг илэрхийлсэн загвар бүхий ажлын хуудсын дэвтэр боловсруулах канал дэвшүүлэх



Өнгө үзэмж, дизайн сайжирсан:

Дасгал ажлын дэвтрийн нүүр хэсэгт сургуулийн зургийг дэвсгэр болгон оруулсан. Говьсүмбэр аймгийн лого, сургуулийн логог тусгасан нь оюутан сурацлагчдад бахархах, бусдад таниулах боломжийг бүрдүүлсэн.

Эхний хуудсанд сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, багшийн зорилго, сурацлагчийн зорилгыг тусгаж өрсөн:

Оюутан сурацлагч бүр сургуулийн алсын хараа, эрхэм зорилгыг мэдэх, тогтоох мөн багшийн зорилго өөрийн зорилгыг мэдсэнээр сурлагын хоцрогдолгүй сурацгаж, зорилготой иргэн төлөвшинө.

Олон төрлийн сонирхолтой даалгавар орсон:

Сурацлагчийг идэвхжүүлэх, олон төрлийн даалгавар гүйцэтгэх дадалд сүргаснаар амжилттай сурацана. Сонирхолтой даалгаврыг гүйцэтгэн бие даах, хамтрах боломжийг олгож байгаа давуу талтай.

Үнэлгээг оруулж өрсөн:

Сурацлахуйн зорилт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд тулгуурлан боловсруулсан ажлын хуудсыг ажиглах явцад багш хоцрогдлыг хянах, сурацлагчийг үнэлэхэд хялбар мөн мөнөжөр, сургалтын арга зүйчид багшийн ажлын явцыг давхар хянах боломжтой.

Цахим хичээлд орох үед ашиглах боломжтой болсон:

Дасгал ажлын дэвтрийг цахим программ ашиглан цахим дэвтэр болгож, хичээл сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх боломжтой.

ДҮГНЭЛТ

Энэхүү илтгэлийг бичихдээ үндсэн 3 зорилт тавьж, зорилтынхоо хүрээнд судалгаа шинжилгээний ажлаа боловсруулж, гүйцэтгэсэн болно.

Илтгэлийн хэлэлцүүлэхэд гол чиг баримжаа болох “Баш сургалтыг дэмжих үйл ажиллагаа” “Мотивацийн тухай менежментийн ойлголт” “Хьютаго” “Дадал хэвшил” зэрэг онолыг судалж практиктай хослуулан туршин хэрэгжүүлсэн. Энэ онолууд нь баш өөрийгөө хөгжүүлэх сэдэл тэмүүлэл өрөх түлхэц болдог. Ажлын хуудсыг өмнөх туршлага дээр үндэслэн арга арчлалыг, сайжруулах суралцдыг танин мэдэх үйлийг сэдэлжүүлэх, идэвхжүүлэх, хамтран ажиллах, туслан зөвлөх, оюутан суралцалцдыг сурч танин мэдэх төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулагч байх гэсэн агуулгын хүрээнд зорилтуудаа тавин баш нар сурлагын хоцрогдлыг хэрхэн нямар аргаар багасгаж байгаа, нямар дасгал дадлага ажлыг ажиллуулдаг талаар судалгаа хийж өөрсдийн гүйцэтгэж байгаа арга зүйгээ уялдуулан судалсан.

Ээлжит хичээл тус бүрд ажлын хуудас боловсруулдаг байсан бөгөөд хичээл сургалтын явцад ажлын хуудсанд сайжруулалт хийсэн. Хоцрогдлыг нөхөх зорилгоор түвшинд тохируулан нэгж хичээлээр бэлтгэж сургалтад туршсан. Үг ажлын хуудсын дэвтрээр дамжуулан суралцалцид хоцрогдсон агуулгыг бие даан судлах, хамтрах чадвар дээшилсэн.

Баш бүр ажлын хуудсаар дамжуулан сурлагын хоцрогдлыг нөхөх боломжтой гэж үзсэн. Тиймээс баш бүр ажлын хуудсыг тогтмол сургалтад хэрэглэдэг боловч хоцрогдлыг тодорхойлох, суралцалцгийг үнэлэх, хянах боломж дутмаг. Мөн цаг хугацаа болон цаас хор их зарцуулдаг.

Суралцахуйн зорилт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд тулгуурлан ажлын хуудсыг нэгж хичээлээр эмх цэгцтэй, олон төрлийн, сонирхолтой, дахин хэрэглэх, мэдлэг чадвар хэрэглээг тодорхойлсон үнэлэх, хянах боломжтой сургуулийн онцлогийг илэрхийлсэн, нэг загварт ажлын хуудсын дэвтрийг боловсруулсан.

Дээрх 3 зорилтын хүрээнд хийсэн ажлын дүгнэлтээс үзэхэд цар тахлаас үүссэн хичээлийн хоцрогдлыг багасгах, нөхөх судлахад дөхөм болгох үүднээс дасгал ажлын дэвтр хэвшүүлэн хэрэгжүүлэх ажлыг туршсан. Хичээлийн эхнээс дадлага ажлын дэвтр ажиллуулах явцад тухайн суралцалцдын түвшинг тодорхойлж түвшин түвшингээр нь дадлага ажлын дэвтрээ сайжруулж бэлдсэн. Цаашид нийт баш нарт хэрэгжүүлэх боломж олгох, бусад сургуулиудтай туршлага солилцох, МСҮТ коллежуудад түгээс дэлгэрүүлэх боломж байна гэж үзлээ.

Дэвшүүлэх санал

- Сургуулийн нийт багш нар нэг загвараар ажлын хуудсыг боловсруулах
- Ерөнхий боловсролын сургуулиудтай туршлага солилцох
- МСҮТ Коллежид түгээн дэлгэрүүлэх

НОМ ЗҮЙ

1. Байгалмаа, Ч. (2015). Боловсролын судалгааны арга зүй. Улаанбаатар.
2. Батболд, Т., Ариунаа, Д., Баярмаа, Б., Батцэцэг, Б., Зол-Эрдэнэ, Д. (2018) Судалгааны ажлын арга зүй. Улаанбаатар.
3. Бадарч, Д., Лхагвасрэн, П., Нарантуяа, С. (2019) Хьютагог. Улаанбаатар.
4. Намжилдагва, Р. (2014). Сургалтын менежментийн онол, арга зүй. Улаанбаатар.
5. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж. Улаанбаатар. 2020
6. Чарльез Духиг, The power of Habit. New York times, 2012
7. Боловсролын үнэлгээний арга зүйн зөвлөмж. Улаанбаатар. 2020
8. Даалгавар боловсруулах арга зүйн зөвлөмж. Улаанбаатар. 2020
9. Augusto Fernández, M. E. Гадаад хэлний чиглэлээр академик гүйцэтгэл ба суралцах дадал зуршил (2012).
10. Картагена Бетета, М. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын бие даах чадвар, сургуулийн гүйцэтгэл ба сурах дадал зуршил хоорондын хамаарал. (2008).



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ УУЛ УУРХАЙН ЖИШИГ
СУРГУУЛЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

ИЛТГЭЛ

Сэдэв: Цахим сургалтын
чанар ба хүртээмж

Илтгэл бичсэн багш

Д.Эрдэнэ-Очир
Н.Марта

АГУУЛГА

1. Оршил	3
❖ Зорилго	
❖ Зорилт	
2. Онолын хэсэг	4-5
❖ Цахим хичээлийн сургалтын чанар ба хүртээмж	
❖ Цахим хичээл хийх ач холбогдол	
3. Практик хэсэг / судалгаа /	6-8
❖ Судалгааны зорилго	
❖ Судалгааны асуулга	
❖ Судалгааны арга зүй	
❖ Судалгаанаас гарсан үр дүн	
4. Дүгнэлт	9
5. Ном зүй	10

АГУУЛГА

Илтгэлийн сэдэв: Цахим сургалтын чанар ба хүртээмж

Илтгэлийн түлхүүр үгс: Сургалтын байгууллага, багш, оюутнууд, цахим хичээл, цахим хэрэглэгдэхүүн, зайнаас суралцах чадвар

Оршил

- Зорилго
- Зорилт

Онолын хэсэг

- Цахим хичээлийн сургалтын чанар ба хүртээмж
- Цахим хичээлийн ач холбогдол

Практик хэсэг / судалгаа /

- Судалгааны зорилго
- Судалгааны арга зүй
- Судалгааны асуулга
- Судалгаанаас гарсан үр дүн

Дүгнэлт

Ном зүй

Хавсралт

Оршил

Зорилго

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн ковид цар тахлын үеийн багш сурагчдад уялдаа холбоот сайжруулж сургалтын чанар үр дүнг дээшлүүлэхийн зэрэгт анхаарах, арга туршлагыг түгээн дэлгэрүүлэхийг зорилгоо буй асуудлыг шийдвэрлэх

Зорилт

- ГСА-ПТК-ийн сургуулийн багш нарын цахим хичээлийн чанарыг ахиулахын тулд багш сурагчдад уялдаа холбоот сайжруулахаар асуулгын аргаар судалгаа авч дүгнэлт гаргана.
- Сургалтын байгууллагын онол ба мэргэжлийн багш нар цахим хичээл заах асуудлыг түлхүү анхаарч өөрийгөө хөгжүүлнэ.

1. ОНОЛЫН ХЭСЭГ

СУРГАЛТЫН ЧАНАР БА ХҮРТЭЭМЖ ГЭЖ ЮУ ВЭ?

Маш сайн төлөвлөсөн хичээл хичээлийн хэрэглэгдэхүүн түүнийг оюутан бүрд хүргэх арга барилыг хүртээмж гэж тодорхойлж болох юм.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулж багш бидэнд нилээдгүй сургамж болсон, дадлага ур чадвар цахим хэрэглээний арга барил шаардсан он жилүүд байлаа.

Түлхүүр үгийг цахим хэрэглээ гэж авч үзвэл цахим хичээл боловсруулах, цахимаар хүртээмжтэй хүргэх, мэдлэгийг цахимаар шалгах үнэлгээ хийх гэх мэтийн арга барилуудыг эзэмшиж байна.

Сургалтын чанар ба хүртээмж гэсэн сэдэв нь маш оновчтой цаг үеэ олсон үндэслэл гэж ойлгож байна

Зайны сургалт гэдэг нэр томъёо гарсан өнөө үед хамгийн үр ашигтай сургалт бол цахим сургалт мөн.

Одоо дижитал оюутан гэдэг нэр томъёо гарч байна .

Тэгвэл багш гэсэн дижитал байх хэрэгтэй.

Орчин үеийн техник технолийн дэвшлийн үед мэргэжлийн багш нарын заадаг техникүүд мөн адил ухаалаг болж байна.

Иймээс цахим хичээл гэдэг бол зайлшгүй шаардлагатай.

ЦАХИМ ХИЧЭЭЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ

2012 онд Монголын мянганы сорилын сан, Монгол улсын шинжлэх ухаан технологийн их сургуулийн багаас гаргасан хүнд машин механизмын засварчин, автомашины засварчин гэсэн мультмедиа хичээл цахим ном манай сургуульд байдгийг Эрдэнэ-Очир багш 2015 оноос хойш мультмедиа хичээлийг сургалтандаа ашиглаж байна.

Марта багш ХАБЭА, гамшгаас хамгаалах мэдлэг гэсэн хичээлийг интернэтээс авч ашиглаж байна.

Цар тахлын үед цахим хичээл маш үр дүнтэй байна гэдэг нь ажиглалтаар батлагдсан.

Цахим хичээлийг насанд хүрэгчидэд мөн насанд хүрсэн зайнаас сурч байгаа оюутнуудад ашиглахад илүү үр дүнтэй нь ажиглагдсан.

Эхний өдөр цахимаар дараагийн өдөр танхимаар хичээллэхэд цахимаар орсон хичээлээ танхим, дадлагын газар хичээлийг бататгах хэлбэрээр явуулхад их үр дүнтэй байсан.

Танхим болон цахим хосолсон сургалтын онол арга зүйн асуудал сэдэвтэй Мандах их сургуулийн илтгэлд тонгоруу буюу flipped гэсэн нэртэй цахим танхимыг хослуулсан сургалт нь олон улсын судалгаагаар маш их үр дүнтэй байсан гэдгийг нотолсон байсан.

Мөн бид нарын ажиглалтаар хичээл зааж байгаа няравын нэг жилийн оюутнууд ч мөн адил дээрх илтгэлийн сэдвийг баталж ярьж байсан.

Няравын ангийн нэг сартай хүүхэдтэй оюутан ярихдаа хүүхдээ хөхүүлж байхдаа багшийн группт оруулсан цахим хичээлийг гар утаснаасаа уншдаг хүүхдээ унтахаар нь дэвтэртээ тэмдэглэж авдаг нь хүний цаг заваа ашиглах нөөц бололцоогоо ашиглах тав тухтай орчин нөхцөлдөө тааруулах гэх мэт олон талын ашигтай байгаа нь нотлогдлоо.

Танхимаар хичээл явуулахад цахимаар заасан хичээлээ бататгаад ойлгоогүй зүйлийг нь тайбарлаад аль болох дадлагын байранд бодит эд анги сэлбэг хэрэгсэл багаж тоног төхөөмжтэй ажиллуулахад оюутнууд маш их дуртай сонирхолтой багш надад ч хүндрэл гарахгүй сайн талтай юм билээ.

СУДАЛГААНЫ АЖИЛ

➤ СУДАЛГААНЫ ЗОРИЛГО


ГСА-ПТК-ийн багш суралцагчдын уялдаа холбоог сайжруулах, цахим хичээлийг чанартай болгохын тулд асуулгын аргаар судалгаа авч байна

➤ СУДАЛГААНЫ ЯВЦ


Судалгаандаа багш, оюутнууд гэсэн хоёр субъектийг сонгож, нийт 10 багш, 26 сурагчийг судалгаанд хамруулж, нээлттэй санал асуулгын хэлбэрээр түүврийн аргаар судалгаа явуулсан.

➤ СУДАЛГААНЫ АСУУЛГА

1. Танд цахим хичээл таалагддаг уу?



2. Цахим хичээлээр хангалттай мэдлэг багш нар өгч чадаж байна уу?



3. Цахим хичээл заахад тулгамдаж буй асуудлууд?

Барш нар	Суралцагчид
- Цаг хугацаа их шаарддаг 2,5 жилийн суралцагчдын идэвх оролцоо муу - Цахим хичээлийн сургалтын талаар шинэ мэдлэг эзэмших бэлтгэл ажлын их - Шинэ сайн программ мэддэггүй - Дэдлагын хичээл ороход хэцүү	- Техник хэрэгсэл дутмаг, орчин шуугиантай, дуу нь муу соносогддог - Цахим хэрэгсэлд тохирсон утастай байх, утасны шаардлага хангагддаггүй - Интернэт датагүй бол орж чадаагүй - Барш заах үед дүрслэл муу

4. Цахим хичээл заах давуу тал?

Барш нар	Суралцагчид
- Товч тодорхой - Хаана ч явж байсан орох боломжтой - Хичээлээ баяжуулж сонирхолтой болгож мэдлэгээ хөгжүүлэх - Насанд хүрэгчдэд цахим хичээл заах дөхөмтэй - Цахим хичээлийн сантай болно	- Бие даан мэдлэгээ дээшлүүлэх боломжтой - Нөхөж үзэх боломжтой - Цаг хугацаа хэмнэнэ - Гэрээ тааваараа хоол хийнгээ сонсоно - Короно тусахгүй

5. Цахим хичээл заах сул тал?

Барш нар	Суралцагчид
- Суралцагчид бүрэн хамрагдахгүй - ирц хангалтгүй оролцоо муу - Амьд харилцаа байхгүй - Цахим хэрэглэгчдүүн дутмаг - Цахим хичээл боловсруулах арга технологий дутмаг	- Интернэтгүй ба сүлжээ муу үед хэцүү - Ганцаараа тул хангалттай юм ойлгохгүй - Идэвх оролцоо муу - Амьд харилцаа байхгүй

➤ **СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ**

- Энэхүү судалгаагаа бид асуулгын аргаар багш, оюутнуудаас судалгаа авсан.

➤ **СУДАЛГААНААС ГАРСАН ҮР ДҮН**

Асуулгын аргаар багш, оюутнуудаас судалгаа авсаны үр дүнд:

- Бүх салбарт багшид тавьж буй мэдлэг, ур чадвар, заах арга зүйн шаардлагыг шинэчлэх
- Энэ зуунд манай багш нарын цахим мэдлэг, ур чадвар, туршлага өнөөгийн шаардлагаас хоцронгүй байгаа нь мэргэшил дээшлүүлэх боломж хязгаарлагдмал байгаа нь багшийн чадвар, сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх
- Цахим хичээлээр чадварлаг оюутан бэлтгэхийн тулд цаашид багш нарыгаа байнга тогтмол хөгжүүлэхэд анхаарах нь зөв гэж үзлээ.

ДҮГНЭЛТ

Судалгаа хийсний үр дүнд оюутнуудын цахим хичээлийг сайжруулахын тулд мэргэжлийн багшийн зүгээс олгож буй цахим хичээл нь оюутан, суралцагчдад олгох мэдлэг, чадвар, хандлагыг ахиулахын зэрэгцээ хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй байгаа нарийн мэргэжлийг онолтой уялдуулан, ур чадварын түвшинг ахиулахын тулд тонгоруу танхимын арга барилыг ашиглаж хичээлийн бичлэг хийж түгээх технологид суурилсан тул эхний алхам нь видео бичлэг хийх, монтажлах, түгээх технологийг сонгоно.

Суралцагчид видеог үзэж зогсоох, ойлгохгүй хэсгээ олон дахин сонсож давтан хийх зэрэг өөрийн сул тал ба давуу талд тохируулан суралцах боломжтой. Энэ загвар нь суралцах үйл явцад сурагчдын хариуцлагыг нэмэгдүүлэхээс гадна гэр бүлийн оролцоог ч дэмжинэ.

Багш нар мэдлэг боловсролоо дээшлүүлж хөгжихийн тулд өөрсдөө идэвх санаачлага гаргах мэргэжлээ дээшлүүлэх арга хэрэгсэл хэлбэрийг оновчтой сонгох ажиллах явцдаа ажлын байран дээр мэдлэг боловсролоо дээшлүүлж тасралтгүй суралцагч байх хэрэгтэй.

Мөн сургалтын албанаас энэ талын арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж хөгжүүлж байх хэрэгтэй.

Жишээ нь: Ахмад ба залуу багш нар, үе тэнгийн багш нарыг хооронд нь туршлага хуваалцах мэдээлээ солилцох, эсвэл тэргүүлэх багш арга зүйч багш зөвлөх багш арга зүйч гэх мэтээр хоорондоо ярих туршлага хуваалцах мэдээлээ хуваалцах нөхцөл бололцоогоор хангах зохион байгуулах шаардлагатай байна.

Багшийн хөгжил гэж багшийн мэдлэг арга зүй ур чадвар боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг хэлнэ.

Хөгжиж буй багш л хүүхдийг хөгжүүлнэ шүү дээ.

1. www.google.mn
2. www.education.com

Хавсралт